




10th Story

Хувирч чөтгөрийг хөөсөн нь!


Transfiguration

Хувирч чөтгөрийг хөөсөн нь!


– 10th Story –



- Есүс** Петр, Иаков, Иохан! Надтай хамт явцгаая.
- Петр** Хаашаа явах вэ? Эзэн минь?
- Есүс** Залбирахаар, уул руу явцгаая.
- Өгүүлэгч** Нэгэн өдөр Есүс шавь нараасаа гурвыг нь дагуулан залбирахаар уул руу явлаа. Өндөрт авирч гармагц шавь нар нь ядарч цөхөрсөн байлаа. Шавь нар нь амьсгал аван амарч байх үед Есүс гүн залбирал хийхээр ганцаараа явав. Есүс үхэл нь ойртож байгааг мэдэж байсан ба тэр чухал явдлыг хуваалцахаар Мосе, Елиа нар яг тэнгэрэлч шиг гарч ирэн Есүстэй ярилцаж байв.
- Мосе** Эзэн минь!
- Елиа** Аврагч минь!
- Есүс** Эрхэм найзууд аа, Миний цаг ойртож байна. Одоо үнэхээр бараг цаг нь болсон юм шиг байна.
- Мосе** Эзэн минь, энэ бол Эцгийн хүсэл.
- Елиа** Таны хүсэл ч бас мөн.
- Есүс** Тийм ээ. Үнэндээ Би Эцгийнхээ дэргэд буцаж очоод муу цаг үеийнхнээс холдмоор байна. Гэвч үнэхээр хүн ачаа юм.
- Мосе** Хэ хэ ... би ч тэр хүнд ачааг бага зэрэг мэднэ.
- Елиа** Ха ха ха тийм шүү ...
- Есүс** Би ганцхан замыг л мэднэ. Гэхдээ үнэхээр, өчүүхэн ч тайван бус зам. Дээр нь хамгийн их өвдөлт нь арай ирээгүй байна.
- Өгүүлэгч** Есүсийг залбирах хооронд Петр, Иаков, Иохан нар унтчихсан байлаа. Тэгэж байгаад гэнэт Есүсийн хувцас гялтганан гэрэлтэхийг хараад нойрноосоо сэрж орхив. Үнэхээр ертөнцийн тэр юунаас ч илүү цав цагаан гэрэл байсан. Тэгээд Есүсийн дэргэд хоёр хүн ярилцаж байв.
- Петр** Хөөх~ Иохан, Иаков! харрр.. харж байа уу?
- Иохан** Э .. Эзэн хувирсан?
- Иаков** А~сар том гэрэл гялтганаж байна!?



Петр	Багшаа, энд үнэхээр гоё юм? Бид гурав энд Багш болон Мосе, Елиа та нарт зориулан майхан барьж өгөх үү?
Өгүүлэгч	Петр сандарч тэвдсэндээ зүгээр л амнаасаа гарсан үгийг хэлж орхижээ. Есүсийн хажууд байсан хүмүүс Елиа юу, Мосе юу гэдгийг ч сайн мэдэхгүй байв. Тэр хоёр хэдийнээ хэдэн зуун жилийн өмнө амьдарч байсан хүмүүс болохоор шууд харж байсан удаагүй. Яг тэр үед гэнэт үүл хуйлран тэднийг нөмөрлөө. Тэгээд Бурханы дуу хоолой сонстов.
Бурхан	Энэ бол Миний хайртай Хүү. Түүний үгийг сонсогтун.
Петр, Иохан, Иаков	Хөөх ~
Өгүүлэгч	Петр, Иаков, Иохан нар сая Бурханы дуу хоолойг үнэхээр сонссон. Тэд ихэд айсан байв. Гурван шавь нь нүүрээ газарт наан залбирч хүндэтгэж эхэлсэн. Тэгтэл үүл сарнин Мосе, Елиа хоёр ч бас алга болов.
Есүс	Зүгээр, зүгээр. Босогтун, одоо хамтдаа уулнаас бууцгаая
Петр, Иохан, Иаков	За Эзэн минь
Есүс	Би үхэгсдээс дахин амилах үе хүртэл энэ явдлыг хэнд ч бүү хэл.
Петр	За ...
Өгүүлэгч	Есүс гурван шавьтайгаа уулнаас бууж ирэх үед, гурван шавь нь Есүсийг үхэгсдээс дахин амилна гэж хэлсэн үгийн утгыг сонирхож байлаа. Тэгээд Есүсийн айлдсанаар өөрсдийнхөө харсан зүйлийг хэнд ч хэлсэнгүй. Ингээд уулнаас бууж ирээд бусад шавь нартайгаа хамт байх болсон бөгөөд шавь нар нь үйл олон хүн цугларчихсан тэдний дунд нэг хүн Есүсийн өмнө өвдөг сөхөрч байгааг харлаа.
Эрэгтэй	Эзэн минь, миний хүүд туслаач. Муу сүнс хүүгийн минь дотор орчихоод сонин хачин үйлдэл хийлгээд байна. Бусад шавь нараас чинь гуйсан боловч хэн нь ч миний хүүгээс муу сүнсийг хөөж чадсангүй.
Есүс	Ха... итгэлгүй үеийнхэн! Хүүгээ Над руу дагуулаад ир.
Эрэгтэй	Та хөөж чадах уу?
Есүс	Итгэдэг хүмүүст боломжгүй зүйл гэж байхгүй. Муу ёрын бузар сүнс чи! Би чамд тушааж байа. Тэр хүүгээс даруй зайлагтун!



- Өгүүлэгч** Яг тэр үед! Есүс чөтгөрийг хүүгээс гаргаж ирсэн. Есүсийг ирэх хүртэл чөтгөр хүүг хүчтэй унагааж зовоож байсан боловч Есүсийг үгийг сонсмогцоо юу ч болоогүй мэт нөгөөх хүү даруй тайван болсон.
- Хүн 1** Үхсэн юм болов уу? үхсэн байна
- Есүс** Үхсэн юм биш. Тэр хүүхэд одоо сайжирна.
- Өгүүлэгч** Есүс тэр хүүд тусалсаны дараа шавь нартайгаа тэндээс явлаа. Тэр явдлыг харсан бүх хүн ихэд гайхацгаасан. Харин Есүсийг шавь нартайгаа үлдэх үед Түүнээс шавь нар нь асуув.
- Шавь нар:** Багшаа, яагаад бид чөтгөрийг зайлуулж чадахгүй байсан юм бэ?
- Есүс** Та нарт хэрэв маш өчүүхэн төдий итгэл л байх юм бол та нар энэ уулыг ч хөдөлгөж чадна